

**ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2020 оны жилийн эцсийн байдлаар)**

2021.02.26

	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Төслийн нэр: Шийдвэрийн дугаар:	Экспортыг Дэмжих Төсөл 5879-MN
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Дэлхийн Банк Групп Зээл (P147438)
3	Хэрэгжүүлэгч байгууллага:	2019 оны 02 дугаар сард батлагдсан ЗГ-ын 87 дугаар тогтоолын дагуу жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилго бүхий төслүүдийн удирдлага, хэрэгжүүлэлтийн үүргийг СЯ-наас ХХААХҮЯ-нд шилжүүлсэн.
	Хэрэгжих нийт хугацаа	2020 оны 09-р сарын 07 – 2023 оны 12-р сарын 30
4	Төслийн зорилтууд	Уул уурхайн бус салбарын ЖДҮ эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх, КОВИД-19 цар тахлын үр нөлөөг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.
5	Зард ал	Төсөв(Нийт шаардагдах зардал)
		Нийт 14.3 сая ЗТЭ (SDR) буюу 20 сая ам. доллар 2020 оны төлөвлөсөн: 4,237.0 мян.ам.доллар, гүйцэтгэл 1,743.2 мян.ам.долл буюу 41.1%-тай байна.
6	Төслийн бүрэлдэхүүн хэсгийн биелэлт	Хэрэгжүүлсэн ажлын талаар бичнэ.
	Бүрэлдэхүүн хэсэг 1: <i>Экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх</i> Хүрэх үр дүн: ЖДҮ эрхлэгчид нийт борлуулалтын эргэлтээ эрчимтэй өсгөх, борлуулалтын эргэн төлөлттэй холбоотой зээлийн эрсдэлийг бууруулах, бизнесийнхээ ашигт ажиллагааг сайжруулах, авлагыг баталгаажуулан нэмэлт санхүүжилт авах боломж бүрдэх ба улмаар макро эдийн засгийн түвшинд, худалдааны урсгалыг дэмжиж, эдийн засгийн өсөлт болон тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.	Үндэсний давхар даатгал ХК-ийн Экспортын даатгалын охин компанийн чадавхыг бэхжүүлэх, мэдлэг олгох чиглэлээр зөвлөх үйлчилгээнд 6.0 мян.ам.доллар зарцуулж, дотоодын зохицуулагч зөвлөх нь төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн ерөнхий зохицуулалтыг хангах хүрээнд зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулах, төслийн бүтцийн өөрчлөлтөд шаардлагатай ажлуудыг гүйцэтгэх, худалдан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөхийн ажлын явцад хяналт тавих, гадаад болон дотоод сургалт зохион байгуулах, бүрэлдэхүүн хэсгийн худалдан авах төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тайлан бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд техник туслалцаа үзүүлэх 2 Олон улсын зөвлөхийн сонгон шалгаруулалтыг зарлаж, ноён Андреас Класен болон Жеф Винсент нарыг сонгосон. Одоогоор зөвлөхүүдтэй гэрээ байгуулах ажил явагдаж байгаа бөгөөд зөвлөх үйлчилгээ 2 сар үргэлжилнэ. Зөвлөх үйлчилгээний үр дүнд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажил дуусгавар болох юм. Бодит байдал дээр зөвлөхийн үйлчилгээ дуусаагүйгээс шалтгаалж хийгдэх ёстой ажлууд хугацаа хойшлогдсон, тендерийн үнэлгээний хороог дахин 2020 оны 12 сарын 07-нд шинэчлэн байгуулсан зэргээс үүдэн тус бүрэлдэхүүн хэсэгт хэрэгжүүлэхээр 6 арга хэмжээ нь төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. ХШҮ-60.0%
	Бүрэлдэхүүн хэсэг 2: <i>Экспортын өрсөлдөх чадвар, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх.</i>	Төслийн бүрэлдэхүүн хэсэг 2.1-ийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 66.7 хувьтай байна.

<p>Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.1 Худалдаа, экспортын бодлого зохицуулалт, чадавх сайжруулах</p> <p>Хүрэх үр дүн: 2.1 Гадаад худалдааны сургалтыг ААН-ийн эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, гадаадын зах зээлд экспортлох бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетингийн судалгааг үйлдвэрлэлд ашигласнаар ААН-үүд мэдлэг, ур чадвараа сайжруулах, экспортоо нэмэгдүүлэх, зах зээлд нэвтрэх боломжийг өргөтгөхөд нь хувь нэмэр оруулна.</p>	<p>ГХЯ, ХХААХҮЯ, Экспортын оролцогч талууд, ААН-үүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, ижил төстэй төслүүд, өмнөх төсөлтэй гэрээгээр хамтран ажиллаж байсан сургалтын байгууллагууд болон МҮХАҮТ-тай уулзалтуудыг хийж, өгсөн санал зөвлөмжийн дагуу 2020 оны сургалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулж, ХХААХҮЯ болон Дэлхийн Банкаар батлуулсан.</p> <p>Ковид-19 цар тахлаас шалтгаалж гадаад, дотоодын зарим сургалтууд тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байна. Экспортод чиглэсэн гадаад худалдааны ерөнхий сургалтыг “Зах зээл судлалын хүрээлэн”, “Хүний хөгжил судалгаа сургалтын төв”-тэй хамтран зохион байгуулж, сертификат олгосон. Малчдын хоршоодын хүсэлтээр нийт 50 малчдын хоршоодын төлөөлөлд “Экспортын баримжаатай ноолуурыг бэлтгэн нийлүүлэх, хоршоодын чанарын удирдлагыг сайжруулах” сургалтыг Тогтвортой ноос ноолуурын эвсэл ОУ-ын байгууллага, UNIDO – Secim нэмүү өртгийн сүлжээ төсөлтэй хамтран зохион байгуулж гэрчилгээ, гарын авлага, төсөл, аж ахуй нэгжүүдийн танилцуулга материал зэргийг тараав.</p> <p>“АРТА” буюу “Ази номхон далайн худалдааны хэлэлцээр ба МУ” цахим сургалт, семинарыг НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс ГХЯ-тай хамтран 10-р сард ГХЯ-ны “Зөвшилцөл” танхимд зохион байгуулсан. Худалдааг хөнгөвчлөх, худалдааны тариф болон худалдааны бусад саад бэрхшээлүүд, экспортын зах зээлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн мэдрэмжийг бууруулах зорилготой сургалтад ГХЯ, МҮХАҮТ, МГЕГ, БНХАУ-ын төлөөлөл, БНСУ-ын төлөөлөл бүхий 50-60 хүнийг хамарсан сургалтыг зохион байгуулсан. Төслийн зүгээс энэхүү сургалтад техник туслалцаа үзүүлж, хамтран ажилласан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-66.7%</p>
<p>Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.2 Олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадварыг сайжруулах</p> <p>Хүрэх үр дүн: 2.2 МУ-д үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсад танигдах дүр төрхийг бий болгох олон улсын маркетингийн стратеги, түүнчлэн Монгол экспорт хөтөлбөрт тусгагдсан болон судалгаагаар тодорхойлогдсон тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүнүүдэд зориулсан тусгай стратегиудыг боловсруулан, хэрэгжүүлэх, үндэсний брэнд бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, тэдгээрт тавигдах стандартуудыг боловсруулах, идэвхжүүлэлт болон олон улсад таниулах гэх зэрэг үйл ажиллагаануудад дэмжлэг</p>	<p><u>Гадаад худалдааны үзэсгэлэн яармаг, экспо чиглэлээр:</u></p> <p>COVID-19 цар тахлын үеийн МУЗГ-аас гаргасан хөл хорио тогтоох шийдвэрүүд болон дэлхийн нийтийн өнөөгийн хязгаарлагдмал нөхцөл байдлын улмаас энэ чиглэлээр дотоодод төдийгүй гадаад улс орнуудад ч аливаа үйл ажиллагаа зохион байгуулагдахгүй, зохион байгуулагдах боломжгүй байна. Гэсэн хэдий ч зарим улс орнуудад цахим үзэсгэлэн худалдаа, экспо зохион байгуулагдах оролдлогууд хийгдэж байгаа жишгээр “Экспорт Монгол 2020 олон улсын цахим форум, үзэсгэлэн худалдаа” арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 18-нд цахим хэлбэрээр¹ зохион байгуулсан. МУ-ын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, экспортыг дэмжиж, тулгамдсан асуудлуудыг хөндөж, тодорхой гарц шийдэл хайхаар дэлхийн өнцөг булан бүрээс жил бүр хуран чуулдаг тус Экспорт Монгол арга хэмжээ нь ийнхүү 6 дахь удаагаа зохион байгуулагдахдаа цахим хэлбэрээр зохион байгуулагдсан нь онцлог болсон юм. Төслийн зүгээс уг арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулж ажилласан. Түүнчлэн, шинэлэг арга хэлбэрээр уламжлалт форум, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шинээр экспортын нэгдсэн сүлжээ бүхий платформыг нэвтрүүлэхэд: ГХЯ, ХХААХҮЯ, Соёлын яам, ҮХГ, ЗГХА-ЖДҮГ, МҮХАҮТ, Экспорт Олон Улсын Худалдааны Төв, USAID</p>

<p>үзүүлэх, ЖДҮ эрхлэгчдийг олон улсын үзэсгэлэн худалдаа, экспод оролцох боломжоор хангах, гадаад зах зээл, гадаад хэрэглэгчдэд хүрэх үүд хаалгыг бизнесүүдэд ойртуулж, нээлттэй болгосноор Монгол улсын нийт экспортын хэмжээ, экспортлогчдын тоо, экспортын бараа, үйлчилгээний тоо, экспортолдог зах зээлүүдийн тоо нэмэгдэнэ.</p>	<p>Best хөтөлбөр Хөгжлийн шийдэл ТББ, АНУ-ын ЭСЯ, АНУ-ын худалдааны яам, Амчам (AmCham), Европ Монголын Худалдааг дэмжих Грам төсөл зэрэг талууд хамтран ажиллаж, зохион байгуулсан.</p> <p>Дээрх арга хэмжээг 2020.12.15-16-нд Corporate зорчид буудлын хурлын танхимуудад зохион байгуулахаар төлөвлөсөн байсан. Эхний 2020.12.15-ны өдөр интернэтийн хурд, техникийн саатал гарч, бэлтгэл ажилд хариуцлагагүй байдал гарсан. Иймд эхний 3 хэлэлцүүлгийг тухайн танхимуудад урьдчилан бичиж, 2020.12.18-нд цахимаар дамжуулж, 4 дүгээр хэлэлцүүлэгт гадаадын илтгэгч нарыг оролцуулан шууд нэвтрүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-65%</p>
<p>Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.3 Түншлэлийн хөтөлбөр Хүрэх үр дүн:2.3 Санхүүгийн дэмжлэгийн хүрээнд тавьсан зорилт биелснээр дотоодын болон экспортын зах зээлд ААН болон Кластерүүдийн өрсөлдөх чадвар сайжирч, МУ-д орж ирэх экспортын орлогын хэмжээ нэмэгдсэн байна. Санхүүгийн буцалтгүй тусламж хүртэгчдийн хувьд экспортын бүтээгдэхүүний нэр төрөл нь олширч, гаргах гадаад зах зээлийн тоо өргөжиж, экспортын борлуулалтын орлого нь нэмэгдэх ба үр дүнд нь тэдний өрсөлдөх чадвар сайжирч, Кластераар дэмжсэн тохиолдолд тухайн салбар нийтдээ хөгжиж, бүтээгдэхүүний чанар стандарт олон улсын жишигт хүрэх бололцоо нээгдэнэ.</p>	<p>Өмнөх төслөөр хэрэгжиж байсан Matching Grant буюу Санхүүгийн дэмжлэг гэж нэрлэж байсныг Productive Partnership Scheme буюу Түншлэлийн хөтөлбөр болгон өөрчилж, батлуулсан.</p> <p>Түншлэлийн хөтөлбөрийг зарлахтай холбоотойгоор бэлтгэл ажлууд бүрэн хийгдсэн болно. Үүнд:</p> <p>Түншлэлийн хөтөлбөрт оруулсан томоохон өөрчлөлтүүд /жнь: бие даасан ЖДҮ-ээс гадна кластеруудыг дэмжихээр болсон/-тэй холбогдуулан Дэлхийн банкны зүгээс асуулт, хэлэлцүүлэг өрнүүлсээр байсан бөгөөд энэ дагуу Түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зааварт нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгаж ажилласан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
<p>Дэд бүрэлдэхүүн хэсэг 2.4 ААН-үүдэд цар тахлын хүндрэлийг даван туулахад үзүүлэх санхүүгийн дэмжлэг Хүрэх үр дүн: 2.4 КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр борлуулалтын орлого нь мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан боловч ажлын байраа хадгалж үлдсэн ЖДҮ-дэд дэмжлэгийг олгох учраас энэ нь тэдгээр ЖДҮ-г ажлын байраа үргэлжлүүлэн хадгалах, бизнес/үйл ажиллагааны тасалдалгүйгээр ажиллах, цар тахлын хямралыг даван туулахад нь дэмжлэг болох болно.</p>	<p>ТХН нь шаардлагатай баримт нотолгоо, тоо мэдээллийг ХНХЯ, НДЕГ, ТЕГ-тай нягт хамтран ажилласны үр дүнд цуглуулан бэлтгэж, ДБ, ДБ-ны УБ оффист шалгуулахаар хүргүүлж, улмаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаас ДБ-нд тус хөрөнгийг шилжүүлэх хүсэлтийг албан ёсоор илгээсэн бөгөөд санхүүгийн дэмжлэгийг Ажилгүйдлийн даатгалын санд нөхөн олгох зөвшөөрлийг авч, энэ дагуу дэмжлэгийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр тус санд бүрэн шилжүүлсэн.</p> <p>Ажилгүйдлийн даатгалын сангаас журамд заасан 3 сарын хугацаанд нийслэл, орон нутгийн шалгуур хангасан нийт 7264 ААН-ийн давхардсан тоогоор 218001 даатгуулагч ажилтанд 43,600,200,000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Төслөөс оруулсан Баянзүрх болон Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй уул уурхайн бус салбарын 332 ЖДҮ эрхлэгчдийн даатгуулагч ажилтанд дэмжлэг олгосон 1.5 сая ам.доллар нь нийт дэмжлэгийн ойролцоогоор 9.81%-тай тэнцэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
<p>Бүрэлдэхүүн хэсэг 2-ын дүн</p>	<p style="text-align: right;">ХШҮ-75.4 %</p>

<p>Бүрэлдэхүүн хэсэг 3: <i>Баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах.</i> Хүрэх үр дүн: Чанарын удирдлага, баталгаажуулалтын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тус тогтолцооны гол оролцогч талуудад чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлсэнээр ЖДҮ эрхлэгчид энэ төрлийн үйлчилгээг дотоодоосоо богино хугацаанд бага зардлаар авах боломжийг бүрдүүлэхэд давхар хувь нэмэр оруулна. Ингэснээр тогтолцооны чадавх бэхжиж, тогтвортой байдал хангагдахаас гадна илүү олон ЖДҮ эрхлэгчид богино хугацаанд экспортлогч болох, экспортлогч ЖДҮ эрхлэгчид экспортоо нэмэгдүүлж, гадаад зах зээлээ тэлэх, импортлогч орнуудын тоог нэмэгдүүлэх боломжоор хангагдаж, улмаар нийт экспортын хэмжээ, экспортын бараа, үйлчилгээний төрөлжилт нэмэгдэж, цөөн тооны импортлогчоос хамааралтай байдал буурна.</p>	<p>Төслийн бүтцийн өөрчлөлтийн санал боловсруулах хүрээнд энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь шинээр нэмэгдсэн бөгөөд нэр хүнд, шилдэг туршлага бүхий олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагын тусламжтайгаар нэг талаас, ЖДҮ эрхлэгчдэд чанарын удирдлага, баталгаажуулалтын олон улсын түвшинд хүрсэн чанартай үйлчилгээг дотоодоосоо авах буюу энэ төрлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашилбал тогтвортой байдлыг хангах үүднээс дотоодын баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагын тогтолцооны гол оролцогч талуудад төслийн гол анхаарал хандуулж буй уул уурхайн бус экспортын салбаруудтай холбогдуулан чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас, сонгогдсон ЖДҮ эрхлэгчдэд олон улсын чанарын гэрчилгээ авахад нь зориулсан чадавх бэхжүүлэх иж бүрэн дадлага, сургалтаар хангах ажлын бэлтгэлийг бүрэн хангасан байна.</p> <p>Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажлуудыг голлон гүйцэтгэх ОУ-ын зөвлөх үйлчилгээний байгууллагыг буюу энэ чиглэлээр ОУ-д нэр хүнд бүхий мэргэшсэн байгууллага болох UNIDO-г худалдан авах ажиллагааны нэг эх үүсвэрийн аргаар сонгон шалгаруулах хүсэлтийг Дэлхийн банканд ХХААХҮЯ-аас 2020 оны 10-р сард хүргүүлсэн бөгөөд Дэлхийн банкны зүгээс 2020 оны 12-р сард зөвшөөрлийг ирүүлсэн.</p> <p>Одоогоор UNIDO-оос ирүүлсэн төслийн санал болон ТХН-ээс боловсруулсан ажлын даалгавруудыг Дэлхийн банк хянан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-60%</p>
<p>Бүрэлдэхүүн хэсэг 4: <i>Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.</i> Хүрэх үр дүн: ТХН нь сургалт, техникийн дэмжлэг, логистик туслалцааны хүрээнд чадавх бэхэжсэнээр Төслийг хэрэгжүүлэх, хянах, үнэлэх зорилготой.</p>	<p>Төслийн хэрэгжүүлэх үндсэн заавар Дэлхийн банкаар 2020 оны 10-р сард батлагдсан. Түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар эцэслэн батлагдаагүй байгаа тул энэ ажил түр хойшлогдсон. 2020 оны сургалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулж, ХХААХҮЯ, ДБ-аар батлуулсан.</p> <p>Төслийн зар, мэдээ мэдээллийг төслийн албан ёсны вэбсайт, нийгмийн сүлжээнд /фэйсбүүк хуудас, youtubесуваг/ тогтмол нийтэлж, олон нийтэд нээлттэй хүргэж байна.</p> <p>Зар, мэдээ мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор фэйсбүүк хуудас дээр идэвхжүүлэн, бүүстэлж байна.</p> <p>Төслийн цахим хуудас: www.edp.mn</p> <p>Төслийн фэйсбүүк хуудас: Экспортыг дэмжих төсөл/export development project</p> <p>Төслийн youtubесуваг: Экспортыг дэмжих төсөл/export development project</p> <p style="text-align: right;">ХШҮ-80%</p>
<p>7 Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Дүгнэлт: Дэлхийн Банкаас хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих” төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт “Эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай буюу 68.8 хувиар үнэлэгдэж байна.</p>

		<p>Дутагдалтай асуудлууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Экспортыг дэмжих төслийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь тодорхой бус, хэт ерөнхий төлөвлөсөн нь уг төслийн дийлэнх арга хэмжээ нь хэрэгжих боломжгүй болж хойшилсон, эцсийн үр дүнг тооцоход хүндрэлтэй байна. Төлөвлөсөн арга хэмжээний 60 гаруй хувийг сургалт, судалгаа хийх, зөвлөх ажил үйлчилгээг сонгон шалгаруулах арга хэмжээ эзэлж байна. 2. Төслийн зардлын төсвийн төслийг боловсруулахдаа хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан тооцоо, суурь судалгаанд үндэслэн боловсруулаагүй байна. 3. Төслөөс Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу холбогдох мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй ба нөхөн байршуулсан боловч зарим мэдээлэл дутуу байна. 4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг shilendans.gov.mn, tender.gov.mn хуудсанд байршуулаагүй. 5. Төслөөс хэрэгжүүлж буй зөвлөх үйлчилгээ, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх гэрээг ХХХААХҮЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Хуулийн хэлтсээр хянуулж, хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэх ажлыг хийдэггүй. 					
8	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг хэрэгжүүлэгч талууд цаашид хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж ажиллах шаардлагатай.					
9	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт, (Өөрийн үнэлгээ: 2020 оны хувьд)	Биелэлт дундаж % (2020 он)	Бүрэлдэхүүн хэсгийн тоо	Бүрэлдэхүүн хэсэг 1	Бүрэлдэхүүн хэсэг 2	Бүрэлдэхүүн хэсэг 3	Бүрэлдэхүүн хэсэг 4
		68.8 %	4	60.0	75.4	60.0	80.0
10	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ ЗГХЭГ-ын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ					

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ